



“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИЗ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан
хуралдуулах тухай:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5, 62 дугаар зүйлийн 62.1.6, мөн хуулийн 60 дугаар зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журмын 2.2 дах заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 10 дугаар сарын 10-ны 5/3869 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэх хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2013 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 хороо, Олимпын гудамж 16, Реженси Резиденс барилга, 2 давхрын 202 тоотын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. “Азия пасифик пропертиз” ХК-ийн хувьцааг хуваах асуудал;
 - 2.2 Хувьцааг хуваах тухай асуудалтай холбоотой дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2013 оны 11 дүгээр сарын 01-нээс эхлэн нийтлэх, хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Дараах бичиг баримтуудыг компанийн төв байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг БДК дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:

- 4.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;
- 4.2. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл, хувьцаа хуваах тухай төсөл;
- 4.3. Хурлаас гарах шийдвэрийн төсөл.



APiP

Азия Пасифик Пропертиз ХК

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган хурал зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах комиссоор БД-ийн “Азия Пасифик Секьюритис” брокерийн компанийг томилсугай.
6. Хурлын санал хураах хуудасны загварыг Хавсралтаар баталсугай.
7. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2013 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 10 цагаар тогтоосугай.
8. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс /Азия Пасифик Секьюритис БДК/-г даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ

Утас: 99903034, 77300660 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,



APiP

Азия Пасифик Пропертиз ХК

2013 оны 10-р сарын 27-ны өдөр

№ 36

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хурал зохион байгуулах комисс томилох болон
санал авах хуудасны загварыг батлах тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 зүйлийн 76.1.3 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2013 оны 12 сарын 07-ны өдрийн 10 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 хороо, Олимпийн гудамж 16, Реженси Резиденс барилга, 2 давхрын 202 тоотын хурлын танхимд хийх болсон тул хурлын даргаар ТУЗ-ийн дарга Ли Майкл Кашелл-ийг томилсугай.
2. Хурал зохион байгуулах комиссыг Азия Пасифик Секьюритис БДК-иар томилж, хурал зохион байгуулах комиссын даргаар Д.Нармандах-ыг томилсугай.
3. Хурал зохион байгуулах комиссыг тооллогын комиссоор ажиллуулахаар томилсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын санал авах хуудасны загварыг хавсралтаар баталсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох ээлжит бус хурлын материалыг бусад холбогдох брокер дилерийн компанид 2013 оны 11 сарын 01-ны өдөр тарааж мэдээлэл хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга Д.Нармандах-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ



Утас: 99903034, 77300660 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,

**“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИЗ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

Компанийн хувьцааг хуваах төслийг сайшаах тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 зүйлийн 76.1.3 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн нэгж хувьцааг 10 болгон хуваах төслийг сайшаасугай.
2. Компанийн хувьцааг хуваах тухай хавсралт төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулан мэдээлэх, төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бэлтгэлийг хангахыг Гүйцэтгэх захирал Д.Галбадрах-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  ЛИ МАЙКЛ КАШЕЛЛ





APPI

Азиа Пасифик Пропертис ХК

2013 оны 10-р сарын 27-ны өдөр

№ 38

Улаанбаатар хот

“АЗИА ПАСИФИК ПРОПЕРТИС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 зүйлийн 76.1.3 дахь заалтыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцааг хуваах асуудалтай холбоотой дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхийг зөвшөөрсүгэй.
- 1.1 Дүрмийн 4.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөх нь: “Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,527,700 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ.”
2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд оруулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал Д.Галбадрах-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  МИ МАЙКЛ КАШЕЛЛ



Утас: 99903034, 77300660 Факс: 976-77300880

Вэбсайт: www.apip-properties.com И-мэйл: info@apip-properties.com

Хаяг: Монгол Улс, 14220 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,